

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/309/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН АРХУСТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: [byambatsogtj@audit.gov.mn](mailto:byambatsogtj@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: [rsamongolia@gmail.com](mailto:rsamongolia@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....	
4. Аудитын тайлан.....	
4.1 Ерөнхий зүйл .....	
4.2 Материаллаг байдал .....	
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	
5. Аудитын илрүүлэлт .....	
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/137  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨВ АЙМГИЙН АРХУСТ СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Д.ЭРДЭНЭТУЯА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Архуст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Архуст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 хөтөлбөр 12 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 85,7 хувиар хэрэгжүүлсэн байна

**Аудитын гол асуудал**

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>142,915,890.64</b>	<b>137,698,790.86</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	92,694,976.13	92,064,802.39
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	92,694,976.13	92,064,802.39
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	92,694,976.13	92,064,802.39
31211	Төрийн сангийн харилцах	92,694,976.13	92,064,802.39
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	490,701.00	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	490,701.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	490,701.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	49,730,213.51	45,633,988.47
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	337,850.00	337,850.00
35130	Эм боох материал	337,850.00	337,850.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	49,392,363.51	45,296,138.47
35410	Бичиг хэргийн материал	2,257,300.00	977,700.00
35420	Аж ахуйн материал	6,676,265.00	1,308,650.00
35440	Түлш, шатах тослох материал	1,222,400.00	657,600.00
35450	Барилгын засварын материал	149,050.00	149,050.00
35460	Хүнсний материал	95,700.00	4,896,020.00
35470	Бусад хангамжийн материал	38,991,648.51	37,307,118.47
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,191,793,992.30</b>	<b>1,145,372,291.89</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,191,793,992.30	1,145,372,291.89
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,178,929,325.63	1,132,595,625.18
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,117,253,407.00	1,117,253,407.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-87,265,401.60	-122,192,270.64
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	82,221,855.60	105,542,855.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	-13,425,013.46	-30,310,937.05
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	73,623,278.89	72,106,462.89
39208	Хуримтлагдсан элэгдэл	-22,949,903.74	-30,176,968.38
39217	Ном	29,471,102.94	20,373,075.76
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	12,864,666.67	12,776,666.71
39301	Програм хангамж	1,526,300.00	1,526,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,093,633.33	-1,181,633.29
39303	Бусад биет бус хөрөнгө	12,432,000.00	12,432,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,334,709,882.94</b>	<b>1,283,071,082.75</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,259,901.00</b>	<b>431,924.88</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	3,259,901.00	431,924.88
<b>413</b>	<b>Өглөг</b>	3,259,901.00	431,924.88
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,769,200.00	00.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	490,701.00	431,924.88
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	431,924.88
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	490,701.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,331,449,981.94</b>	<b>1,282,639,157.87</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,331,449,981.94	1,282,639,157.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	236,473,340.70	236,473,340.70
51101	Өмч: - төрийн	236,473,340.70	236,473,340.70
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	792,031,970.09	743,305,126.02
51210	Өмнөх үеийн үр дүн	792,031,970.09	792,115,950.09
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-48,810,824.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	302,944,671.15	302,860,691.15
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,334,709,882.94</b>	<b>1,283,071,082.75</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>801,020,808.40</b>	<b>662,191,549.96</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>136,968,308.40</b>	<b>20,168,949.96</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	136,968,308.40	20,168,949.96
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	7,865,748.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	792,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	7,073,248.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>664,052,500.00</b>	<b>642,022,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	590,070,400.00	599,506,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	590,070,400.00	599,506,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	14,730,800.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,730,800.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	59,251,300.00	42,516,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	59,251,300.00	42,516,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>602,769,534.48</b>	<b>700,372,946.85</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>602,769,534.48</b>	<b>700,372,946.85</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	558,412,469.48	673,181,346.98
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	384,314,206.00	446,479,819.52
210101	Үндсэн цалин	288,726,139.00	330,703,104.45
210102	Нэмэгдэл	73,662,282.00	101,223,580.07
210104	Урамшуулал	21,925,785.00	14,553,135.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	48,350,871.87	57,326,837.10
210201	Тэтгэврийн даатгал	33,327,970.31	38,848,130.37
210202	Тэтгэмжийн даатгал	3,844,512.83	4,589,660.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,068,890.29	4,088,594.84
210204	Ажилгүйдлийн даатгал	717,949.72	891,004.69
210205	Эрүүл мэндийн даатгал	7,391,548.72	8,909,447.09
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	27,525,430.00	45,586,760.13
210301	Гэрэл, цахилгаан	21,270,630.00	33,549,160.13
210302	Түлш, халаалт	6,102,750.00	11,537,600.00
210303	Цэвэр, бохир ус	152,050.00	500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	00.00	15,447,097.00
210401	Бичиг хэрэг	00.00	2,904,050.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	1,416,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	1,151,200.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	9,975,847.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	31,955,280.00	29,124,020.00
210502	Хоол, хүнс	31,955,280.00	29,124,020.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,180,950.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,180,950.00	1,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж</b>	2,610,000.00	2,824,717.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	792,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,610,000.00	2,032,217.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	62,475,731.61	75,392,096.23

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,269,911.00	8,066,873.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,251,380.00	3,923,550.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	40,954,440.61	63,401,673.23
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>44,357,065.00</b>	<b>27,191,599.87</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>43,455,480.00</b>	<b>27,110,560.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,724,680.00	27,110,560.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,730,800.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>901,585.00</b>	<b>81,039.87</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	901,585.00	81,039.87
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>198,251,273.92</b>	<b>-38,181,396.89</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>10,629,427.18</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	10,629,427.18
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-10,629,427.18</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>198,251,273.92</b>	<b>-48,810,824.07</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>664,052,500.00</b>	<b>649,888,348.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>7,865,748.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>00.00</b>	<b>7,865,748.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>00.00</b>	<b>7,865,748.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	792,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	7,073,248.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>664,052,500.00</b>	<b>642,022,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>590,070,400.00</b>	<b>599,506,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	590,070,400.00	599,506,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>14,730,800.00</b>	<b>00.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,730,800.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>59,251,300.00</b>	<b>42,516,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	59,251,300.00	42,516,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>571,357,523.87</b>	<b>650,518,521.74</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>571,357,523.87</b>	<b>650,518,521.74</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>523,674,938.87</b>	<b>619,691,581.87</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>384,314,206.00</b>	<b>446,047,894.64</b>
210101	Үндсэн цалин	290,165,865.00	331,609,937.33
210102	Нэмэгдэл	72,572,556.00	100,029,972.31
210104	Урамшуулал	21,575,785.00	14,407,985.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>48,350,871.87</b>	<b>57,326,837.10</b>
210201	Тэтгэврийн даатгал	33,327,970.31	38,812,130.37
210202	Тэтгэмжийн даатгал	3,844,512.83	4,597,660.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,068,890.29	4,095,594.84

210204	Ажилгүйдлийн даатгал	717,949.72	892,004.69
210205	Эрүүл мэндийн даатгал	7,391,548.72	8,929,447.09
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>26,406,280.00</b>	<b>41,435,560.13</b>
210301	Гэрэл, цахилгаан	21,270,630.00	33,549,160.13
210302	Түлш, халаалт	5,004,950.00	7,386,400.00
210303	Цэвэр, бохир ус	130,700.00	500,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>26,739,630.00</b>	<b>30,289,000.00</b>
210502	Хоол, хүнс	26,739,630.00	30,289,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>1,000,000.00</b>
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,745,600.00</b>	<b>3,340,717.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,184,800.00	792,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,560,800.00	2,548,217.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>31,118,351.00</b>	<b>40,251,573.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,277,171.00	34,367,773.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,841,180.00	5,883,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>47,682,585.00</b>	<b>30,826,939.87</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>46,781,000.00</b>	<b>30,745,900.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,050,200.00	30,745,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,730,800.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>901,585.00</b>	<b>81,039.87</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	901,585.00	81,039.87
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>92,694,976.13</b>	<b>-630,173.74</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>92,694,976.13</b>	<b>-630,173.74</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>21,350.00</b>	<b>92,694,976.13</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>92,694,976.13</b>	<b>92,064,802.39</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	236,473,340.70	302,944,671.15	792,031,970.09	1,331,449,981.94
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	236,473,340.70	302,944,671.15	792,031,970.09	1,331,449,981.94
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	83,980.00	83,980.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	236,473,340.70	302,944,671.15	792,115,950.09	1,331,533,961.94
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-83,980.00	00.00	-83,980.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-48,810,824.07	-48,810,824.07
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	236,473,340.70	302,860,691.15	743,305,126.02	1,282,639,157.87

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	700,455,448.00	608,001,921.74	-92,453,526.26	86.8
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	700,455,448.00	608,001,921.74	-92,453,526.26	86.8
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	666,270,348.00	577,256,021.74	-89,014,326.26	86.6
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	523,545,600.00	446,047,894.64	-77,497,705.36	85.2
210101	Үндсэн цалин	356,893,100.00	331,609,937.33	-25,283,162.67	92.9
210102	Нэмэгдэл	147,969,400.00	100,029,972.31	-47,939,427.69	67.6
210104	Урамшуулал	18,683,100.00	14,407,985.00	-4,275,115.00	77.1
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шилжүүлэг</b>	65,443,700.00	57,326,837.10	-8,116,862.90	87.6
210201	Тэтгэврийн даатгал	44,501,900.00	38,812,130.37	-5,689,769.63	87.2
210202	Тэтгэмжийн даатгал	5,235,400.00	4,597,660.11	-637,739.89	87.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,188,300.00	4,095,594.84	-92,705.16	97.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,047,100.00	892,004.69	-155,095.31	85.2
210205	Эрүүл мэндийн даатгал	10,471,000.00	8,929,447.09	-1,541,552.91	85.3
2105	<b>Нормативт зардал</b>	30,539,600.00	30,289,000.00	-250,600.00	99.2
210502	Хоол, хүнс	30,539,600.00	30,289,000.00	-250,600.00	99.2
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,107,300.00	3,340,717.00	-1,766,583.00	65.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,184,800.00	792,500.00	-392,300.00	66.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,922,500.00	2,548,217.00	-1,374,283.00	65.0
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	41634148.00	40251573.00	-1,382,575.00	96.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,750,348.00	34,367,773.00	-1,382,575.00	96.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,883,800.00	5,883,800.00	0.00	100.0
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	34185100.00	30745900.00	-3,439,200.00	89.9
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	34,185,100.00	30,745,900.00	-3,439,200.00	89.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	34,185,100.00	30,745,900.00	-3,439,200.00	89.9
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	604,033,200.00	607,221,100.00	3,187,900.00	100.5
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	602,848,400.00	607,221,100.00	4,372,700.00	100.7
131001	Улсын төсвөөс санхүүжих	602,848,400.00	607,221,100.00	4,372,700.00	100.7
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	1,184,800.00	00.00	-1,184,800.00	0.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,184,800.00	00.00	-1,184,800.00	0.0
4	<b>Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	92,694,976.13	92,694,976.13	
5	<b>Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	92,064,802.39	92,064,802.39	
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	32.00	31.00	-1.00	96.9
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	16.00	-1.00	94.1
620003	Үйлчлэх ажилтан	14.00	14.00	0.00	100.0

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Архуст сумын Ерөнхий боловсролын сургууль нь эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, хариуцлагатай, бие даан суралцах, амьдрах чадвартай иргэн төлөвшүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус байгууллага нь Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Архуст сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 оныг "Сургуулийн менежментийг сайжруулах" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 12 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 86,8 хувиар биелүүлж ажилласан байна.

Төв аймгийн Архуст сумын Ерөнхий боловсролын бүрэн дунд сургууль нь 32 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Боловсролын тухай хууль
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Архуст сумын Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын тухай хуулийг хэрэгжүүлэн хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэх үйл ажиллагаа явуулж, үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд, мөн Сангийн яам болон харьяа яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

2023 он 11 сарын 7 өдөр аймгийн засаг даргын нэрэмжит үзлэг шалгалт хамрагдсан. 90.0 хувьтай үнэлэгдсэн.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Архуст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Архуст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 51,638.8 мянган төгрөгөөр буюу 3,8% хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	92,694.9	92,064.8	-630.0
Авлага	490.7		-490.7
Урьдчилгаа			
Бараа материал	49,730.2	45,633.9	-4,096.2
Үндсэн хөрөнгө	1,191,793.9	1,145,372.2	-46,421.7
Нийт хөрөнгө	<b>1,334,709.8</b>	<b>1,283,071.0</b>	<b>-51,638.8</b>
Өр төлбөр	3,259.9	431.9	-2,827.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,331,449.9	1,282,639.1	-48,810.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<b>1,334,709.8</b>	<b>1,283,071.0</b>	<b>-51,638.8</b>

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны эцэст мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 630.0 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн цалин, нэмэгдэл зэргийг хэмнэснээс мөнгөн хөрөнгө данс өссөн байна.

Авлага дансны үлдэгдэл байхгүй байна.

Бараа материал дансны үлдэгдэл 4,096.2 мянган төгрөгөөр буурсан нь Сургуулийн захирлын 2023 оны 12 сарын 000 өдийн 000 тоот тушаалаар бусад хангамжийн материал 9,975.4 мянган төгрөгийн бараа материалыг акталснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө данс 49,421.7 мянган төгрөгөөр буурсан нь: Сумын ИТХ-н 2023 оны 6 сарын 18 ний өдрийн 06 тоот тогтоолоор 8,180.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж 1,947.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 2,326.8 мянган төгрөг, ном 10,629.4 мянган төгрөг тус тус акталсантай, мөн элэгдэлтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 700,455.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 45,342.1 мянган төгрөг нийт зарлагыг 745,797.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 745,797.5 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 745,797.5 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 745,797.5 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 650,437.4 мянган төгрөг буюу 86,8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 92,453.5 мянган төгрөгөөр, үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшууллыг 77,497.7 мянган төгрөгөөр, бүх төрлийн даатгалын зардлыг 8,116.8 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардлыг 250.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлыг 3,149.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

д/д	71802-Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226-Байр ашиглалтын үйлчилгээ	1,569.0	1,568.7	0.3	99,99%
2	80312-Сургалт семинар	784.5		784.5	
3	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,569.0	1,569.0		100%
4	81801-Үдийн цай хөтөлбөр	34,185.1	30,745.9	3,439.2	85,9%
5	81806- Дотуур байрны үйлчилгээ	53,873.7	39,626.0	14,247.6	73,6%
6	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	16,274.0	16,274.0		100%
7	81823- Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	3,530.3	3,530.0	0.3	99,9%
8	81834- Боловсролын стандарт	439,029.0	370,437.7	68,591.3	84,4%
9	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	141,382.8	136,951.9	4,430.8	96,9%
10	81844- Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	7,073.2	6,506.2	567.0	92%
11	81848- Сурах бичгийн түрээс	1,184.8	792.5	392.3	66,9%
12	80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	45,342.1	42,435.5	2,906.5	96,6%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Архуст сумын Ерөнхий боловсролын сургууль нь нэмэлт санхүүжилтийн төсөв байхгүй.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71802-80226	2023-12-31	Байр ашиглалтын үйлчилгээ	99,9%	1,569.0	1,568.7
2	71802-80312	2023-12-31	Сургалт семинар		784.5	
3	71802-81605	2023-12-31	Эрүүл мэндийг дэмжих	100%	1,569.0	1,569.0
4	71802-81801	2023-12-31	Үдийн цай хөтөлбөр	85,9%	34,185.1	30,745.9
5	71802-81806	2023-12-31	Дотуур байрны үйлчилгээ	73,6%	53,873.7	39,626.0
6	71802-81816	2023-12-31	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	100%	16,274.0	16,274.0
7	71802-81823	2023-12-31	Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	99,9%	3,530.3	3,530.0
8	71802-81834	2023-12-31	Боловсролын стандарт	84,4%	439,029.0	370,437.7
9	71802-81835	2023-12-31	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	96,9%	141,382.8	136,951.9
10	71802-81844	2023-12-31	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	92%	7,073.2	6,506.2
11	71802-81848	2023-12-31	Сурах бичгийн түрээс	66,9%	1,184.8	792,5
12	71802-80111	2023-12-31	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	96,6%	45,342.1	42,435.5

Үдийн цай болон дотуур байрны үйлчилгээ, сурах бичгийн түрээс хөтөлбөр дутуу хэрэгжсэн нь сурагчдын ирц муу байсан нь нөлөөлсөн.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Архуст сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд цахим дэлгүүрээс 8 ширхэг таблет 7,192.0 мянган төгрөгөөр, 8 ширхэг зөөврийн компьютер 6,369.0 мянган төгрөгөөр, 3 ширхэг ширээ 810.0 мянган төгрөг тус тус худалдан авсан байна. Аймгийн Боловсролын газраас тендер шалгаруулсан газруудаас шууд худалдан авалт хийсэн. Худалдан авах ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг батлуулж зохих хууль, журмын дагуу гүйцэтгэсэн.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Архуст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12

дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах ажиллагчидтай холбоотой авлагыг барагдуулах, дансны үлдэгдлийг улирал, жилийн санхүүгийн эцэст баталгаажуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн аудитор С.Дашдондог, аудитор Б.Мягмар нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Архуст сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн, нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 495,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 9,900.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7,920.0 мянган төгрөгөөр тооцлоо. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хэмнэж ажилласны үр дүнд ажиллагсдад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Архуст сумын ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэн ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорх хэмнэлт гаргасан байна.Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 77,497.7 мянган төгрөгөөр
- Нормативт зардал болон даатгалын зардлыг 8,367.4 мянган төгрөгөөр
- Хангамжийн бараа материал болон бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлыг 1,766.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хөтлөлтийг шалгахад 2023 онд тус эрүүл мэндийн төв нь 159 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 150 мэдээллийг байршуулж 9 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3-д “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хууль, журмын заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Архуст сумын Ерөнхий боловсролын сургуулийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 2 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад хэрэгжээгүй тул аудитын тайланд зөрчлөөр тусгасан болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувь биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
<b>Акт</b>	1	76.6	1	76.6	100%
<b>Албан шаардлага</b>	1		1		
<b>Зөвлөмж</b>	2	611.8	2	611.8	100%
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>688.4</b>	<b>4</b>	<b>688.4</b>	<b>100%</b>

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар нийт 1,836.8 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 200.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 1,636.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага хүргүүлсэн.

#### **5.1 Төлбөрийн акт**

1. Зардлын данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Анхан шатны баримтын бүрдэлгүй томилолтын зардал 200.0 мянган төгрөг гаргасан зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар бүлэг 6.4.1-д “Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төсөвлөж зарцуулах”, санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. .

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

#### **5.2 Албан шаардлага**

1. Хөрөнгийн данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Хүүхдийн үдийн цайны хүнсний материалыг орц нормын дагуу бодож тооцоогүйгээс 1,636.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/166 дугаартай хамтарсан тушаалын 1-р хавсралт, 3-р хавсралтыг мөрдөж ажиллах гэсэн заалтыг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.6-д “Эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан” гэж заасныг үндэслэн холбогдох тушаал, зааврыг дагаж мөрдөн ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Томилолтын зарлал анхан шатны баримтгүй	1	200.0	1	200.0								
Хүүхдийн үдийн цайны хүнсний материалын орц нормын дагуу мөрдөж ажиллаагүй	1	1,636.8			1	1,636.8						
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>1,836.8</b>	<b>1</b>	<b>200.0</b>	<b>1</b>	<b>1,636.8</b>						

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
159 мэдээ оруулахаас 6 мэдээ хугацаа хоцроосон	1						1	
Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)